

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№18/479

ШУС, НУС

2017

**РЕДАКЦИЙН НИЙТЛЭЛ, НЭВТРҮҮЛГИЙН БОДЛОГЫН ЭДИЙН ЗАСГИЙН
ХАРААТ БУС БАЙДЛЫН АСУУДАЛД**

Д.Сандагсүрэн*

*МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн докторант

Түлхүүр үг: редакцийн эдийн засгийн хараат бус байдал; хэвлэл, мэдээллийн хэрэгслийн санхүүгийн зах зээл; сэтгүүлчийн нийтлэх эрх чөлөө; хэв-лэлийн салбар дахь төрийн санхүүгийн шууд бус дэмжлэг

Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл нь эдийн засаг, бизнесийн хувьд хэн нэгнээс хараат байвал жинхэнэ утгаараа чөлөөт байж чадахгүй. Манай орны хэвлэл, мэдээллийн хэрэгслийн үүсгэн байгуулагч нь хөрөнгө мөнгөтэй хувь хүн, байгууллага, компани, эвсэл холбоод байдаг. Иймд “удирдаачийн дохиур” хэвлэл, мэдээллийн хэрэгслийн өмчлөгчийн гарт байдаг нь ойлгомжтой. Тэд зарим мэдээллийг захиалах, өөрийн эрх ашигт нийцэхгүй мэдээ, мэдээллийг нийтлэхгүй байхыг эрхлэгч болон редакторуудад ямар нэгэн хэлбэрээр ойлгуулдаг нь нууц биш юм. Энэ нь эргээд редакцийг хараат байдалд оруулдаг. Эдийн засгийн эрх ашигт хэт хөтлөгдөх нь олон нийтийн мэдээллийн хэрэгслийг бодит мэдээллийг нуун дарагдуулах, орхигдуулах, иргэдийг үнэн зөв мэдээллээр хангах үүргээ биелүүлж чадахгүйд хүргэдэг.

Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн орлогын хууль ёсны эх сурвалж нь зар сурталчилгаа байдаг. Зар сурталчилгааны зах зээл дээр олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдийн дунд шууд өрсөлдөөн бий болдог. Тэгэхээр чөлөөт, хараат бус хэвлэл мэдээллийг хөгжүүлэхэд зайлшгүй чухал хүчин зүйл нь зах зээлийн хувь хэмжээний төлөөх өрсөлдөөн юм. Зах зээлийн хүчин зүйлээр зохицуулагддаг барууны орнуудад хэвлэлийн бизнесийн ашигтай загварыг бий болгож чадсан байдаг. Гэхдээ энэ нь бас төгс төгөлдөр зүйл хараахан биш. Энэ загвар нь зах зээл, зар сурталчилгааны үнэ цэнийг мэдэрдэг, хүчтэй өрсөлдөөн бүхий эдийн засгийн орчинг шаарддаг. Цөөн хүн амтай манай орны хувьд хэт олон ижил төрлийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэлтэй болсон, тэдний олонх нь ашиг сонирхол бүхий хэсэг бүлгийн дэмжлэгт дулдуйддаг, үлдсэн хэсэг нь зар сурталчилгааны зах зээл хомс санхүүгийн бэрхшээл дунд амь тээх төдий амьдарч байгааг бид мэднэ. Хэвлэл, мэдээллийн хэрэгслүүд “бизнес мэдээ” гэх мэтийн төлбөрт нийтлэл, төлбөрт нэвтрүүлэгт ихээхэн зай, цаг өгдөг болсноо санхүүгийн

бэрхшээлтэй холбон тайлбарладаг. Энэ нь хэвлэл мэдээллийнхний аргагүй байдал мэт харагдавч, нөгөө талдаа жирийн иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, илүү бодитой олон талт мэдээлэл авах эрх ашигт ноцтой харшилж байдаг.

Монголын хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн санхүүгийн сул дорой байдал нь сонин хэвлэл, радио, телевизүүд бие даан хөгжихөд учирч буй гол саад бэрхшээл болоод байна. Томоохон зар сурталчилгааг байнга нийтлүүлдэг байгууллагууд хэвлэлийг хяналтдаа байлгахыг хичээдэг нь нууц биш. Мөнгөтэй компаниуд “хаалтын гэрээ” гэгчийг хийж, өөрийн компанийн тухай сөрөг муу мэдээ материалыг нийтлэхгүй байх тухай үг үсгийг зар сурталчилгаа нийлүүлэх удаан хугацааны гэрээ гэгчийнхээ хаа нэгтээ шургуулдаг нь ил болсон. Төрийн байгууллагууд төсвийн мөнгөөр хэвлэл сонинг олон тоогоор захиалдаг, реклам нийлүүлдэг гэдгээрээ гул барих, харин редакцийн ажилтнуудын хувьд олон тоогоор сонин захиалсан байгууллагаа шүүмжлэхгүй гэсэн бичигдээгүй хууль аль ч хэвлэл, мэдээллийн байгууллагад байдаг л зовлон. Энэ нь хэвлэл, мэдээллийн хэрэгслийг хянах, өөрийн ашиг сонирхолд үйлчлүүлэх гэсэн хэсэг бүлгийн хувьд аятайхан өгөөш болдог байна.

Тэрчлэн улс төр, бизнесийнхэн цалин багатай сэтгүүлчдийг элдэв урамшууллаар урхиддаг нь нууц биш юм. Редакторууд сониноо, редакцийн хамт олноо санхүүжүүлэхийн тулд мөнгөтэй рекламд зай талбай, цаг

хугацааг хайрладаггүй. Сэтгүүлчид нь оройн хоол, үнэгүй амралт, зугаалга, гадаад дотоодод аялах зэргээр мөнгөтэй хүмүүсийн халаасанд багтах нь энүүхэнд. Сэтгүүлчдийн цалин хөлс бага, ажлын цаг урт, илүү цагийн мөнгө өгдөггүй зэргээс болж дээрх маягаар худалдагдахад хүрдэг. Сэтгүүлчдийн цалин хөлсийг нэмэгдүүлэх, нийгмийн хамгааллын талаар ажил олгогчтой хэлэлцээр хийх зэргээр тэдний эрх ашгийг хамгаалдаг хүчтэй үйлдвэрчний эвлэл ч байхгүй байна. Сэтгүүлчдийн мэргэжлийн байгууллага ч энэ талаар дорвитой ажил хийхгүй байна. Үүнээс үүдэн олон сэтгүүлч төлбөрт нийт-

лэлээс шан харамж хүртдэг аюултай балчигт шигдэхийн зэрэгцээ хэвлэл, мэдээллийн хэрэгсэл нь өөрөө эргээд мөнгөтэй байгууллага,

хүмүүсээс хараат болж байна. Энэ бүгд сэтгүүлч-

дийг мэргэжилдээ үнэнч байх ёс суртахууныг үгүй хийж, сэтгүүлчид худалдагдах, авлигад өртөх, цаашлаад иргэдийн үнэнийг мэдэх эрхийг хангах сэтгүүлчийн үүргээ умартах гол шалтгаан болж байна.

Хараат бус хэвлэл мэдээллийг хөгжүүлэхэд хэвлэл, мэдээллийн хэрэгсэл ашигтай бизнес болохуйц санхүүгийн загвар дутмаг байгаа нь хэвлэл мэдээллийн зах зээлийн тулгамдсан асуудал болов. Сонин, хэвлэлийн тоо олон ч, ашигтай бизнес эрхлэх хэмжээний тиражтай хэвлэл цөөн байна. Сонин, хэвлэлийн захиалгын тоо бага, үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагч болон засаг захиргааны байгууллагын

«

Хараат бус хэвлэл мэдээллийг хөгжүүлэхэд хэвлэл, мэдээллийн хэрэгсэл ашигтай бизнес болохуйц санхүүгийн загвар дутмаг байгаа нь хэвлэл мэдээллийн зах зээлийн тулгамдсан асуудал болов

»

татаас, эсвэл улс төр, бизнесийн сонирхлоос хүчтэй хамаарч буй өнөөгийн нөхцөлөөс зайлсхийх арга хэвлэл, мэдээллийн зах зээлд хомс байна. Манай үндэсний хэмжээнд тардаг гэх өдөр тутмын цөөн сонин төрийн байгууллагууд болон төрийн өмчийн оролцоотой мөнгөтэй гэгддэг хэдэн компанид гуйлгаар шахаад ч хэвлэлийн тираж нь дээд тал нь 10 мянгаас хол давдаггүй гэдгийг бид мэднэ. Тэгвэл *“Хэвлэл мэдээллийн ихэнх бизнест том хөрөнгө оруулалт-гүйгээр нэвтэрч болдоггүй. Тэгээд ч хэвлэл мэдээлэл нь зах зээлээ өргөтгөх дарамт дор эзэд болон шийдвэр гаргагчдын эдийн засгийн нуугдмал сонирхлын дор янз бүрийн агуулгыг бий болгодог”*¹ хэмээн судлаач А.Оюунгэрэл дээрх хамаарлын талаар сонирхолтой дүгнэлт хийсэн байна.

Монгол Улсад 2006 онд Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийг баталж, төрийн мэдлийн радио, телевиз олон нийтийнх болж өөрчлөгдсөн. Гэвч дээрх хоёр мэдээллийн хэрэгслийн өргөн нэвтрүүлгийн орлогын гол эх үүсвэр нь үйлчилгээний хураамж, улсын төсвөөс бүрддэг байна. Монголын үндэсний радио, телевизийн санхүүжилтийн гуравны нэг нь үзэгчдийн хураамж, гуравны хоёр нь улсын төсвөөс бүрддэг учраас санхүүгийн хувьд Засгийн газраас шууд хараат гэж дүгнэхэд болох юм.

Монголын үндэсний олон нийтийн телевизийн өөрийнх нь дүн мэдээгээр улсын хэмжээнд 1.265.000 үзэгчтэй, жилдээ 4 сувгаар 18982 цагийн өргөн нэвтрүүлэг цацдаг байна. Энэ байгууллага нь өнөөдөр үндэсний хэмжээнд өргөн нэвтрүүлгээрээ хамгийн олон үзэгч, сонсогчтой, монополь байдалтай байгаа нь олон нийтийн

өргөн нэвтрүүлгийн хувьд өрсөлдөөний давуу тал юм.

*“Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз нь ойрын жилүүдэд орон нутгийн оршин суугчдын мэдээллийн гол эх сурвалжийн хувьд чухал үүрэг гүйцэтгэх төдийгүй, үүн дээрээ дөрөөлж улс төрийн “гол тоглогч” хэвээр байх байдал ажиглагдаж байна”*² гэж “Фридрих Эбертийн сан”-гаас хийсэн судалгаанд өгүүлсэн байна. Энэ хүчирхэг, монополь мэдээллийн хэрэгслээр олон урсгалт мэдээллийг дамжуулах, аливаа үзэл бодлыг нээлттэй байлгах, мэдээллийн тэнцвэрийг хадгалах зарчим алдагдаж байгаад гол аюул нь оршиж байна. Үүний зэрэгцээ хэт монопольчлол ноёрхож байгаа цагт редакцийн хараат бус байдал бүрэн алдагддаг бөгөөд цензур тавих, мэдээллийн агуулгад оролцох, мэдээллийн тэнцвэрт байдлыг алдагдуулах зэрэг чөлөөт хэвлэлийн мөн чанарт харш үйл хийдэгт хамгийн том хор уршиг нь байгаа юм.

Бага төсөв зардаг зарим FM радиог эс тооцвол орон нутгийн бараг бүх хэвлэл, мэдээллийн хэрэгсэл төлбөрт нийтлэл, төлбөрт нэвтрүүлгээс хараат байна. Гол ивээн тэтгэгч нь улстөрчид, бизнес эрхлэгчид, өөрийгөө сурталчлахыг хүссэн сум орны удирдлага, эсвэл төслөө сурталчлах зорилготой төрийн бус байгууллагууд байна. Хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдийн эзэмшил нь хувь хүн, аймгийн ИТХ-д албан ёсоор байдаг боловч үнэн хэрэгтээ эрх баригч гол хоёр намын хүмүүс ард нь байдаг. Аймаг, сумын Засаг даргын Тамгын газрын үзүүлж буй санхүүгийн “тусламж” нь орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл оршин тогтноход нэн чухал. Тийм учраас орон нутаг

дахь хэвлэлүүд хичнээн хичээсэн ч энэ туйлширсан орчин нөхцөлөөс ангид байх боломжгүй болдог. Хэрэв орон нутаг дахь сөрөг хэвлэл эрх баригчдад шүүмжлэлтэй хандвал дарамт шахалт дор амьдрахад тун хүнд болно. Ийм байдлаас үүдэн орон нутгийн хэвлэл, мэдээлэл нь улс төр, бизнесийн ашиг сонирхлоос зайлсхийх боломж тун хомс байна.

Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 2-т “Орон нутгийн радио, телевиз тухайн орон нутгийн иргэдийн нийтлэг эрх ашигт үйлчилж, тэдний өмнө хариуцлага хүлээж, хяналт дор нь үйл ажиллагаа явуулна”, мөн зүйлийн 3-т “Орон нутгийн радио, телевизийн ажиллах бүтэц, зохион байгуулалт, санхүүжилт болон үйл ажиллагаа явуулах журмыг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална” гэж заасан байдаг. Гэхдээ орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл хаанаас яаж санхүүжихийг хуульд зааж өгөөгүй байна. Энэ шалтгааны улмаас орон нутгийн телевизүүд олон нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллага болж өөрчлөгдөхгүй, орон нутгийн засаг захиргааны байгууллагын мэдэлд хэвээр байна. Иймээс Олон нийтийн радио, телевизийн тухай хууль аль ч утгаараа төр захиргааны байгууллагаас хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд нөлөөлж байгаа нөлөөлөл, оролцоог эцэс болгож чадахгүй байна.

Уг нь сэтгүүлч хэвлэл, мэдээллийн хэрэгслийн өмчлөгч хэн байхаас үл хамааран сэтгүүлчийнхээ ёс зүйд нийцүүлэн хараат бусаар ажиллах ёстой. Хэвлэл, мэдээллийн байгууллагын үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагч, хувь эзэмшигч редакцийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох,

тэрчлэн нийтлэл, нэвтрүүлгийн ивээн тэтгэгч, санхүүжүүлэгч тухайн нийтлэл, нэвтрүүлгийн агуулгад нөлөөлөхийг хуулиар хориглосон тохиолдолд л сэтгүүлчийн дээрх эрхийг хангах боломжтой болно.

Хэвлэл мэдээллийн хараат бус байдал дахь санхүүгийн нөлөөллийг тандах зорилгоор зарим өдөр тутмын сонинны сэтгүүлчдийн дунд судалгаа хийж үзэхэд судалгаанд оролцсон нийт сэтгүүлчдийн 60 хувь нь өөрийн бэлтгэсэн нийтлэлээ чөлөөтэй нийтэлж нэвтрүүлж чаддаггүй. Үүнд зар сурталчилгаа өгдөг, ивээн тэтгэгч байгууллага нөлөөлдөг гэсэн байна.

Өөрсдийн амьдрах санхүүгийн аргагүй байдалтай үүнийгээ холбон тайлбарладаг ч, сэтгүүлчдийн хараат бусаар ажиллахад санхүүгийн дэмжлэг үзүүлдэг байгууллагуудын нөлөөлөл их байдаг нь дээрх судалгаанаас харагдаж байна.

Өөрөөр хэлбэл, хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд төрөөс гэхээсээ илүүтэй эдийн засаг, бизнесийн болон эзнээс, эзэмшигчээс хараат байх явдал нэлээд түгээмэл байна.

Хэвлэл, мэдээллийн хэрэгслийг чөлөөтэй ажиллахад эдийн засгийн бие даасан байдал юу юунаас чухал гэдэг нь ойлгомжтой. Тэгэхээр редакцийн хараат бус байдлыг хангахад төрийн дэмжлэг туслалцаа энд үгүйлэгдэж байна.

Хэвлэл мэдээллийн хараат бус байдалд санхүүгийн хүндрэл нөлөөлдөг нь гадны улс орнуудад ч түгээмэл ажиглагддаг зүйл юм. Тиймээс редакцийн эдийн засгийн хараат бус байдлыг төрөөс дэмжих бодлого барьдаг зарим орны туршлагыг энд хуваалцахад буруудахгүй юм. Энэ нь эдийн засгийн буюу санхүүгийн хэлбэрийн дэмжлэг байдаг. Гэхдээ шууд

санхүүгийн дэмжлэг, мөнгө хөрөнгө, сонгомол татаасаас илүүтэй шууд бус татаас олгохыг дэмждэг. Учир нь шууд буюу сонгомол татаасыг улс төрийн хараат байдалд оруулах арга заль гэж үздэг байна.

Хэвлэл, мэдээллийн хэрэгслийн салбарт олгох шууд бус төрийн санхүүгийн тэтгэлэг нь хэвлэл мэдээллийн компаниуд болон бүтээлд өгдөг ерөнхий шинж чанартай зүйл юм. Энэ талаар зарим орны туршлагаас харахад:

-Европын ихэнх улс орнууд олон нийтийн хэвлэл, мэдээллийн сектортом, өдөр тутмын сонины НӨАТ-ыг хөнгөлөх зэргээр зарим төрлийн татварын хөнгөлөлт үзүүлдэг.

-Францад сэтгүүлчдэд татварын хөнгөлөлт үзүүлдэг тогтолцоо байдаг.

-Германд хуулийн дагуу хэвлэл мэдээллийн хэрэгсэлд шууд татаас өгөхийг хориглодог. Харин тодорхой нөхцөлийн дагуу мэдээний тогтмол хэвлэлд шуудангийн хөнгөлөлт олгох, сонин сэтгүүлд хөрөнгө оруулалтын зээл хэлбэрээр шууд бус татаасыг олгож болдог.

-Голландын хэвлэлийн компаниуд хэвлэл мэдээллийн зах зээлийн хувь хэмжээнд өөрсдөө зохицуулалт хийдэг. 1993 онд хэвлэлийн компаниуд хэвлэл нийтлэлээ сонины улсын зах зээлийн 1/3 хүртэл хэмжээнд байх хязгаар тогтоохоор шийдвэрлэжээ. Мөн сонин хэвлэлийн НӨАТ-ыг 6 хувь хүртэл бууруулах хөнгөлөлт үзүүлдэг байна.

-Италид 1981 онд Хэвлэл мэдээллийн тухай хуулиар хэвлэл мэдээлэлд татаас олгох талаар журам тогтоожээ. Хэвлэлийн компаниудад бага татвар ногдуулах, тээвэр, шуудан, харилцаа холбооны төлбөрийг хөнгөлөх замаар шууд бус татаасыг олгодог. Харин шууд татаасыг ашгийн бус хэвлэл,

сэтгүүлчдийн холбоо, жижиг хэвлэлүүд болон улс төрийн намын хэвлэлд олгодог байна.

-Монгол Улсад сонин хэвлэлийн газруудыг НӨАТ-аас чөлөөлөх татварын хөнгөлөлтийн тогтолцоо бий.

Ишлэл

¹Оюунгэрэл.А. “Олон түмний харилцааны онол” УБ. 2009. х.98-99

²Азийн хэвлэл мэдээллийн барометр судалгаа. “Фридрих Эбертийн сан”. УБ. 2012.

³Олон нийтийн радио, телевизийн тухай хууль. <http://iegalinfo.mn/>

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Багерстам. Э. Ардчилсан нийгэм дэх хэвлэлийн эрх чөлөө (Орч. Я.Сүхбаатар). УБ. 2003.
2. Болд-Эрдэнэ. Б. Олон нийтийн харилцаа. УБ. 2006.
3. Зулькафиль. М., Чойсамба. Ч. Чөлөөт хэвлэл: Өчигдөр, өнөөдөр, маргааш. УБ. 2001.
4. Зулькафиль. М., Чойсамба. Ч. Сэтгүүлчийн ёс зүй. УБ. 2004.
5. Зулькафиль. М. Монголын олон нийтийн мэдээлэл: Нэг намын үзэл суртлаас олон ургальч үзэл хүртэл. УБ. 2010.
6. Оюунгэрэл. А. Олон түмний харилцааны онол. УБ. 2009.
7. Цэнджав. До. Хэвлэл мэдээллийн менежмент. УБ. 2004.
8. Олон нийтийн радио, телевизийн тухай хууль

Резюме

Автор этой статьи подчеркивает что финансовая самостоятельность является самым важным фактором независимости прессы. Самый низкий уровень тиража и неширокий финансовый рынок не дают возможность экономической независимости СМИ. Автор приходит к выводу что независимость прессы есть прежде всего свобода журналистов независимо работающих от учредителя, собственников и рекламодателей.